



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20.18 он 10 сарын 05 өдөр

Дугаар 3Г-1,
1164

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
М.ЭНХБОЛД ТАНАА

Монгол Улсын Засгийн газрын
гишүүнийг томилуулах
тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Янгугийн Содбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын албан тушаалд томилуулах асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

001493



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

2018 оны 10 сарын 05 өдөр

Дугаар E/24

Төрийн ордон, Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА**

Зөвшилцөх саналын тухай

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдаар Янгугийн Содбаатарыг томилох асуудлыг зөвшилцөхөөр ирүүлсэн таны 2018 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн ЗГ-1/163 дугаартай албан бичгийг хүлээн авч, холбогдох материалуудтай танилцлаа.

Уг асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэх нь зүйтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА

0000000195

ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын гишүүнийг
томилуулах саналын тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д Ерөнхий сайд Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, Засгийн газрын гишүүнийг томилох, албан тушаалаас чөлөөлөх, огцруулах тухай саналаа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр заасан.

Иймд Улсын Их Хурлын гишүүн Янгугийн Содбаатарыг Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын албан тушаалд томилуулах саналаа хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Авлигатай тэмцэх газрын албан бичгүүд, нэр дэвшигчийн дэлгэрэнгүй танилцуулгыг тус тус хавсаргав.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2018 оны ...дугаар
сарын ... -ны өдөр

Дугаар...

Улаанбаатар
хот

Монгол Улсын Засгийн газрын гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт, Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдаар Янгугийн Содбаатарыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2018 оны ...дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

1. Янгугийн Содбаатарыг Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдын албан тушаалд томилуулахаар танилцуулж байна.

2. 1974 онд Архангай аймагт төрсөн.

3. 44 настай.

4. Эрэгтэй

5. Гэр бүлийн байдал: Эхнэр, хүүхдийн хамт амьдардаг.



6. Хэзээ, хаана, ямар сургууль дамжаа төгссөн, мэргэжил, эрдмийн зэрэг, цол

1992 онд Өвөрхангай аймгийн Хархорин сумын арван жилийн 1 дүгээр дунд сургуулийг, 1997 онд Улаанбаатар их сургуулийг, 2004 онд Удирдлагын академийг тус тус суралцан дүүргэсэн.

Физикч-инженер мэргэжилтэй, Доктор (Ph.D) зэрэгтэй. Англи, орос хэлний мэдлэгтэй.

7. Ажилласан байдал

1997-1999 онд ШУА-ийн харъяа Дулааны техник, үйлдвэрийн экологийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, 1999-2005 онд Монголын Ардчилсан Социалист Залуучуудын Холбоонд нарийн бичгийн дарга, ерөнхий нарийн бичгийн дарга, 2005-2006 онд Үйлдвэр худалдааны сайдын зөвлөх, 2006-2008 онд Үйлдвэр худалдааны дэд сайд, 2009-2011 онд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дэд дарга, дарга 2011-2012 онд МАН-ын Нарийн бичгийн даргаар тус тус ажиллаж байсан бөгөөд 2012 оноос Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

8. Ажилласан хугацаа /жилээр/

Төрийн албанд 13 жил, улс төрийн албан тушаалд 10 ажилласан.

9. Энэ албан тушаалд томилуулах үндэслэл

1.Засгийн газраас дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх чадвар;
2.Тухайн ажил, үүргийг гүйцэтгүүлэхэд хуримтлуулсан туршлага, мэдлэг;
3.Танхимын зарчмаар ажиллах чадвар;
4.Удирдан зохион байгуулах чадвар, ажил хэрэгч чанар.

Монгол Улсын Ерөнхий сайд

 У.ХҮРЭЛСҮХ

2018 оны 10 дугаар сарын 4-ний өдөр



МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn


2018.10.04 № 05/8074
танай 2018.10.04-ны № 200/2154

Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлгийг хянасан тухай

Монгол Улсын Засгийн газрын гишүүн-Зам, тээврийн хөгжлийн сайдаар томилогдохоор нэр дэвшсэн Янгугийн Содбаатарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан хориглолт, хязгаарлалтыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй байна.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА
ЭРХЭЛСЭН КОМИССАР



Х.ХАШБААТАР

0014123